



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/209

Улаанбаатар хот

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан
орчны болон дэд бүтцийн хүртээмжийн
үнэлгээ хийх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, 42.1.4, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Дүүргийн аж ахуй нэгж, албан байгууллагуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан орчны болон дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийх ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Үнэлгээ хийх ажлын хэсгийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, зарцуулагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үнэлгээ хийхэд шаардагдах 222.000 (Хоёр зуун хорин хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 сарын 17 ны өдрийн 166 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ДЭД БҮТЦИЙН
ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИНД ҮНЭЛГЭЭ ХИЙХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн

Ахлагч:

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Гишүүд:

Тохижилт худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

1 дүгээр Хорооны Засаг дарга

2 дугаар хорооны Засаг дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн хөгжлийн
нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Дүүргийн харааны бэрхшээлтэй иргэний төлөөлөл
(зөвшилцсөнөөр)


Дүүргийн тэргэнцэртэй иргэний төлөөлөл
(зөвшилцсөнөөр)

Дүүргийн тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэний төлөөлөл
(зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн
дарга:

Нийгмийн хөгжлийн хэлтсийн хөдөлмөр, нийгмийн
хамгаалал, хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 сарын 17 ны өдрийн 1007 дугаар
Захирамжийн хоёрдугаар хавсралт



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН
ДЭД БҮТЦИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИНД ҮНЭЛГЭЭ
ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Нэг. Зорилго:

Иргэдийн оролцоо, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилтот жилийн хүрээнд төрийн болон төрийн өмчийн аж ахуй нэгж, албан байгууллага үйлчилгээний байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчны стандартыг хангуулах, тэднийг нийгмийн харилцаанд саадгүй оролцох боломжийг бүрдүүлэх.

Хоёр. Хугацаа:

2023 оны 11 дүгээр сарын 02-03-ны өдрийн хооронд

Гурав. Хамрах хүрээ: Дүүргийн төрийн болон үйлчилгээний дараах байгууллагуудын барилга байгууламж, зам гарц, тэмдэг тэмдэглэгээнд үнэлгээ хийнэ. Үүнд:

- 1) Засаг даргын Тамгын газар
- 2) 1, 2 дугаар хороо
- 3) Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс
- 4) Онцгой байдлын байдлын хэлтэс
- 5) Нийгмийн даатгалын хэлтэс
- 6) Улсын бүртгэлийн хэлтэс
- 7) Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
- 8) Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв
- 9) "Хангай" цогцолбор сургууль
- 10) 44 дүгээр цэцэрлэг
- 11) 207 дугаар цэцэрлэг
- 12) Соёлын Ордон
- 13) Эрүүл мэндийн төв
- 14) Биеийн тамир, спортын хороо
- 15) 2 дугаар хорооны хэсгийн эмнэлэг
- 16) Жавхлант дэлгүүр
- 17) Хэнз хонгор дэлгүүр

Дөрөв. Хүрэх үр дүн:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд бүтцийн хүртээмжтэй орчны стандарт хангагдаж, тэдний нийгмийн харилцаанд саадгүй оролцох боломж бүрдсэн байна.



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 сарын 17 ны өдрийн 1000 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН
ДЭД БҮТЦИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ ОРЧИНД ҮНЭЛГЭЭ
ХИЙХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ**

№	Бараа	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Түлш	л	30	2400	72.000
2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд урамшуулал	хүн	3	50.000	150.000
Нийт дүн					222.000